Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,289.5 сая төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	594.7	356.2	(238.5)	(40.1)
Авлага	187.4	172.5	(14.8)	(7.9)
Урьдчилгаа	39.9	-	(39.9)	(100.0)
Бараа материал	83.7	96.7	13.0	15.6
Үндсэн хөрөнгө	2,897.4	4,467.1	1,569.7	54.2
Нийт хөрөнгө	3,803.0	5,092.5	1,289.5	33.9
Өр төлбөр	201.4	8.2	(193.1)	(95.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,601.6	5,084.3	1,482.6	41.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,803.0	5,092.5	1,289.5	33.9

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдлүүдэд материаллаг өөрчлөлтүүд гарсан бөгөөд тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосон, сумын ЗДТГ-т үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн өсөлтүүд тус тус нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 356.2 сая төгрөг болж, өмнөх оноос 238.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	594.7	356.2	(238.5)
Төгрөг	594.7	356.2	(238.5)
Төрийн сангийн харилцах	594.7	356.2	(238.5)
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	594.7	356.2	(238.5)

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны өөрчлөлтөд: Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 286.6 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 80.6 сая төгрөгөөр тус тус буурч, нөхөн сэргээхийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 102.5 сая төгрөгөөр, нэмэлт дансны төвлөрүүлэлтийн үлдэгдэл 18.0 сая төгрөгөөр, ахмадын сангийн үлдэгдэл 7.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн ба эцсийн үлдэгдэл 238.5 сая төгрөг нь холбогдох байгууллагуудын төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

ИТХ: - Мөнгөн гүйлгээний тайланд орлогын дансны ангилал буруу илэрхийлсэнийг залруулсан.

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүйг залруулсан.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 172.5 сая төгрөг болж, өмнөх оноос 14.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	0.5	0.5	-
Байгууллагаас авах авлага	97.4	0.0	(97.4)
Хувь хүмүүст олгосон зээл	89.4	172.0	82.5
Дүн	187.4	172.5	(14.8)

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд байгууллагаас авах авлагыг бүрэн барагдуулж, Сум хөгжлийн сангаас 131.0 сая төгрөгийн зээл олгож, жилийн эцэст авлага дансны өөрчлөлтөд 82.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: - Түрээсийн гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулаагүйгээс түрээслэгчдээс 1.3 сая төгрөгийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй, орон нутгийн орлогын дансан түрээсийн орлогын 50 хувийг 150.8 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байхад авлагаар бүртгэж тайлагнаагүйг залруулсан.

3.4.3 Урьдчилгаа

Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, макет 150 га газарт тодотгол оруулах ажил 2023 онд дуусаж өмнөх оны 39.0 сая төгрөгийн урьдчилгаа хаагдсан байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 96.7 сая төгрөг болж, өмнөх оноос 13.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	37.3	65.2	27.8
Тусгай зориулалттай материал	37.3	65.2	27.8
Хангамжийн материал	19.4	26.2	6.7
Бичиг хэргийн материал	7.1	7.6	0.5
Аж ахуйн материал	4.3	4.5	0.2
Сэлбэг хэрэгсэл	7.8	13.8	5.9
Түлш, шатах тослох материал	0.2	0.3	0.1
Мал амьтад	26.9	5.4	-21.5
Дүн	83.7	96.7	13.0

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өөрчлөлтөд: сумын ЗДТГ-ын үлдэгдэл 11.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Энэ нь тайлант онд тухайн байгууллагад үнэ төлбөргүйгээр 174.8 сая төгрөгийн материал нийлүүлэгдсэн, өвч тэжээл болон бусад нөөц 27.8 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 4.7 сая төгрөгөөр нэмэгдэж, мал амьтад 21.5 сая төгрөгөөр хорогдсонтой холбоотой байна.

ЗДТГ: - Тайлант хугацаанд мал борлуулахдаа УСНББОУС-ыг мөрдөж ажиллаагүйд зөвлөмж хүргүүлсэн.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,467.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,569.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,749.2	4,319.3	1,570.0
Барилга, байгууламж, орон сууц	1,601.7	2,146.6	544.9
Авто-тээврийн хэрэгсэл	495.5	644.5	149.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	324.3	336.8	12.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	79.7	90.2	10.5
Бусад үндсэн хөрөнгө	1,981.8	3,168.3	1,186.5
Ном	11.0	11.4	0.4
Биет бус хөрөнгө	148.2	147.8	-0.3
Программ хангамж	5.2	5.8	0.6
Бусад биет бус хөрөнгө	146.9	146.9	0.0
Дүн	2,897.4	4,467.1	1,569.7

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлтөд ЗДТГ-ын хөрөнгө 1,541.7 сая төгрөгөөр, ИТХ-ын хөрөнгө 28.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд ЗДТГ 1,868.7 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: -Үлдэгдэл өртөггүй ҮХ-д 577.1 мянган төгрөгийн элэгдэл илүү тооцсон, 394.9 мянган төгрөгийн ҮХ-ийн ашиглалтад орсон огноог программд оруулаагүйгээс тайлант хугацааны элэгдлийг тооцоолоогүй орхигдуулсаныг залруулсан.

- Тайлант хугацаанд аймгаас 50.8 сая төгрөгийн өвс тэжээл үнэ төлбөргүй өгсөнийг санхүүгийн тайланд худалдаж авсанаар буруу бүртгэсэн, сумын ОНХС-аас 88.9 сая төгрөгийн өвсийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсаныг залруулсан.

ИТХ: -Үндсэн хөрөнгийн ашиглах жил, оруулаагүй элэгдлийн зардал тооцоогүйг залруулсан.

- Эд хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу зохион байгуулаагүйд албан шаардлага өгсөн.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 8.2 сая төгрөг болж, өмнөх оноос 193.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	201.4	8.2	-193.1
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	8.2	8.2
Байгууллагад төлөх өглөг	201.4	0.0	-201.4
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0005	0.0005	-
Дүн	201.4	8.2	-193.1

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ЗДТГ-ын өр төлбөр 8.1 сая төгрөгөөр нэмэгдэж, ОНХС-ийн өглөг 123.9 сая төгрөгөөр, төвлөрүүлсэн үлдэгдлийн өглөг 77.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: - Санхүүгийн тайланд тусгагдсан 8.2 мянган төгрөгийн авлага, 330.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүйд зөвлөмж хүргүүлсэн.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,084.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,482.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,518.3	1,518.3	-
Хуримтлагдсан үр дүн	1,916.3	3,398.9	1,482.7
Өмнөх үеийн үр дүн	4,700.6	1,916.3	(2,784.3)
Тайлант үеийн үр дүн	(2,784.3)	1,482.7	4,267.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167.1	167.0	(0.0)
Дүн	3,601.6	5,084.3	1,482.7

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: ЗДТГ-ын тайлант үеийн үр дүн 1,550.6 сая төгрөгөөр, ИТХ-ын үр дүн 29.7 сая төгрөгөөр, СХС-ийн үр дүн 1.9 сая төгрөгөөр, НСС-ийн үр дүн 103.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, ОНХС-ын тайлант үеийн үр дүнгийн 202.6 сая төгрөгийн буурсантай холбоотой байна. Эдгээр өөрчлөлтөд үнэ төлбөргүйгээр үндсэн хөрөнгө, бараа материал нэмэгдэл болон үйл ажиллагааны зардлын зарцуулалт бага зэрэг нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: - Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг 347.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэнийг залруулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 888.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,664.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 544.9 сая төгрөг, нийт зарлагыг 3098.2 сая төгрөгөөр төсөвлөсөн.

Аймгаас хянаж ирүүлсэн төслийг 297.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 297.4 сая төгрөгөөр, харьяа төсөвт байгууллагуудын зардлыг 1,078.1 сая төгрөгөөр, сумаас аймагт татан төвлөрүүлэх орлогыг 528.0 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс ОНХС-д төвлөрүүлэх 189.7 сая төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 888.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2023 оны орон нутгийн төсөв батлах тухай 2023 оны 12/04 дугаар тогтоолоор Хатанбулаг сумын татварын болон татварын бус орлогыг 1,498.3 сая төгрөгөөр баталсан, сумын ИТХ-ын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 14/03 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 297.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,788.8 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр 2,576.5 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 787.6 сая төгрөгөөр давсан байна. Гүйцэтгэл 144.0 хувиар биелсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/ сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /хуулгаар/	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлого	1,000.0	1,638.5	638.5	163.9
2	Үйл ажиллагааны орлогын татвар	13.7	6.1	-7.5	44.9
3	Хадгаламжийн хүүгийн орлого	42.0	36.4	-5.6	86.7
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	10.6	9.3	-1.3	87.6
5	Бусад орлогын тавар	4.9	46.7	41.8	949.2
6	Үл хөдлөх хөрөнгийн татвар	6.6	3.0	-3.6	45.1
7	Галт зэвсгийн албан татвар	4.1	1.9	-2.2	46.8
8	Малын тоо толгойн албан татвар	90.3	15.3	-75.0	16.9
9	Улсын тэмдэгтийн хураамж	9.0	25.1	-16.1	278.6
10	Ан агнах зөвшөөрлийн хураамж	50.0	77.6	27.6	155.2
11	Газрын төлбөр	226.1	355.1	129.0	157.0
12	Хог хаягдлын хураамж	50.0	10.5	-39.5	21.0
13	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	201.5	201.5	-	100.0
14	Торгуулийн орлого	50.0	88.5	38.5	176.9
15	Нэр зааж ангилагдаагүй орлого	30.0	61.0	31.0	203.3
	НИЙТ	1,788.9	2,576.5	787.6	-

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 7 нэр төрлийн орлого 922.4 сая төгрөгөөр давж, 7 нэр төрлийн орлого 134.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого төлөвлөсөн дүнгээс 638.5 сая төгрөгөөр давсан нь Ханги хилийн боомтын тээврийн компаниудын цалингийн орлого орсонтой;
- Бусад орлогын татвар төлөвлөсөн дүнгээс 41.8 сая давсан нь төлөвлөгдөөгүй Чингүүн транс ХХК-ийн жолооч нараас суутгасан 10 хувийн татварын орлого орсонтой;
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого төлөвлөсөн дүнгээс 16.1 сая төгрөгөөр давсан нь газрын дуудлага худалдааны тэмдэгтийн хураамжийн орлоготой;
- Ан агнах зөвшөөрлийн орлого төлөвлөсөн дүнгээс 27.6 сая төгрөгөөр давсан нь ангийн төлөвлөгөө оны эхэнд байсан боловч хагас жилийн ИТХ-р ан агнах ААН тодорхойгүй энэ онд ан агнах боломжгүй гэсэн шалтгаанаар төлөвлөгөөг тодотгосон байсан боловч ан агнаж орлого орсонтой; холбоотой байна.
- Газрын төлбөрийн орлого 129.0 сая төгрөгөөр давсан нь Монлаа ХХК болон Рео ХХК-ийн 2021 оноос хойш газрын төлбөрийг барагдуулсантай; холбоотой байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн дүнгээс 7.5 сая төгрөгөөр тасарсан нь ноосны урамшууллын орлогын суутгал тооцоноос бага орсонтой; холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 5.6 сая төгрөгөөр тасарсан нь Төрийн банк, Хаан банкны хадгаламж буурсантай; холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлого 1.3 сая төгрөгөөр тасарсан нь Ханги хилийн боомтод газар эзэмшдэг иргэдийн хөрөнгө борлуулсны орлого буурсантай;

- Үл хөдлөх хөрөнгийн орлого 3.6 сая төгрөгөөр тасарсан нь Чандман илч ХХК-ийн үл хөдлөхийн албан татвар төлөгдөөгүйтэй;
- Галт зэвсгийн албан татварын орлого 2.2 сая төгрөгөөр тасарсан нь Галт зэвсэг эзэмшигч иргэд цагдаад буугаа хураалгасантай;
- Малын тоо толгойн албан татварын орлого 75.0 сая төгрөгөөр тасарсан нь байгалийн цаг уур хүндэрч зуншлага муу, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой Малын татвар өндөр болон төлөхгүй гэж эсэргүйцэж байгаатай;
- Хог хаягдлын төлбөр 39.5 сая төгрөгөөр давсан нь Хангийн тээврийн компаниудын хураамж төвлөрөөгүйтэй тус тус холбоотой байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

1. Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 зорилтод хөтөлбөрт зориулан сумын ИТХ-ын 2022 оны 08/03 дугаар тогтоолоор 2,706.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,104.8 сая төгрөгийг урсгал зардалд, 1,059.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 541.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр баталжээ.

Нийт зардлын 1,498.4 сая төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 262.1 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 888.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 57.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 2,706.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 14/03 дугаар тогтоолоор 516.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 3,222.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор сумын татварын болон татварын бус орлогыг 290.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,788.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын татварын болон татварын бус орлого 2,582.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 888.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 179.1 сая төгрөг, нийт 3,644.2 сая төгрөгийг бүрдүүлэн, орлогын биелэлт 133.3 хувьтай байна.

Сумын татварын болон татварын бус орлого 1,788.8 сая төгрөгөөс орон нутгийн төсөвт байгууллагуудад 1007.3 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн санд 114.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ сая төгрөгөөр/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /дутуу +, илүү -/	Хувь
1	Сумын татварын болон татварын бус орлого	1,788.9	2,576.5	787.6	144.0
2	Үйл ажиллагааны орлого	57	179.1	122.1	314.2
3	ОНХС, ТАТөсөл	888.5	888.5	0.0	100.0
4	Өмнөх оны үлдэгдлээс	487.9	264.1	-223.8	54.1
Дүн		3,222.3	3,908.2	685.9	82.3

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,768.2 сая төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 304.1 сая төгрөгөөр, туслах үйл ажиллагааны зардлыг 1.3 сая төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 19.2 сая төгрөгөөр, мэдээлэл, сурталчилгааны зардлыг 0.3 сая төгрөгөөр, орон нутгийн нөөц хөрөнгийг 2.0 сая төгрөгөөр, хур хог хаягдал, орчны бохирдлыг 0.5 сая төгрөгөөр, багийн ИНХ-ын даргын урамшууллын зардлыг 2.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ сая төгрөгөөр/

Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,749.9	2,445.8	(304.1)	88.9
2	Баг, хорооны ҮАЗардал	125.6	106.4	(19.2)	84.7
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.4	0.1	(0.3)	25.0
4	Туслах үйл ажиллагааны зардал	45.7	44.4	(1.3)	97.2
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	130.0	128.0	(2.0)	98.5
6	Хур хог хаягдал, орчны бохирдол	18.0	17.5	(0.5)	97.2
7	Улсын их баяр наадам	5.0	5.0	-	100.0
8	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	13.9	11.3	(2.6)	81.3
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	9.7	9.7	-	100.0
	Дүн	3,098.2	2,768.2	(330.0)	89.3

Харьяа төсөвт байгууллага, сангуудын зардлын гүйцэтгэлээр авч үзэхэд сумын ЗДТГ 66.7 сая төгрөгөөр, ИТХ 4.1 сая төгрөгөөр, ОНХС 95.1 сая төгрөгөөр, Хоргоо хөгжүүлэх сан 40.9 сая төгрөгөөр, Нөхөн сэргээх сан 39.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: - Төрийн сангийн мэргэжилтний цалин хөлсийг зөрүүтэй тооцож, 550.0 мянган төгрөгийг илүү олгосонд төлбөрийн акт тогтоосон.

- Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд урамшуулал бодож олгосонд төлбөрийн акт тогтоосон.

ИТХ: - Батлагдсан төсвийн гүйцэтгэл тайлагнахдаа зардал хооронд гүйлгэж илэрхийлсэнийг залруулсан.

2. Аймгийн ИТХ-ын 2023 оны төсөв баталсан 2023 оны 12/04 дугаар тогтоолоор Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын байгууллагуудын үйлчилгээ ашиглалтын зардлын төсвийг 386.0 сая төгрөгөөр аймгийн төсвөөс олгохоор баталсан байна.

Хүснэгт 11. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын санхүүжилтийн хуваарилалт, төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ЭМТөв	33.0	29.3	3.7	88.8
2	Сургууль	180.0	161.8	18.2	89.9
3	Цэцэрлэг	49.0	40.1	8.9	81.8
4	Соёл	124.0	89.2	34.8	71.9
	Дүн	386.0	320.4	65.6	83.0

Гүйцэтгэлээр 314.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, тогтмол зардалд 304.9 сая төгрөгийг, урсгал засварын зардалд 9.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3. Аймгийн болон Сумын ИТХ-аар сумын орлого, зардлын нийт төсвийг 3098.2 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3668.9 сая төгрөг буюу 144.03 хувийн биелэлттэй бөгөөд, үүний 2,576.5 сая төгрөг нь сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого, 888.5 сая төгрөг нь аймгаас олгосон ОНХС-ын санхүүжилт, 314.2 сая төгрөг нь улсын төсөвт байгууллагуудын байр ашиглалтын зардлын санхүүжилт, 179.1 сая төгрөг нь төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагааны орлого байна. Сангуудын оны эхний үлдэгдлээс 517.3 сая төгрөг байна.

Нийт зардал 2,768.2 сая төгрөг буюу 89.3 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд цалин, НДШ-ийн зардал 640.8 сая төгрөг буюу 23.1 хувийг, тогтмол зардал 343.6 сая төгрөг буюу 12.4 хувийг, ОНХС-ын зардал 1,289.8 сая төгрөг буюу 46.5 хувийг, бусад зардал 494.0 сая төгрөг буюу 18 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Төсвийн нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төсвийн зардлын гүйцэтгэл			
		Батлагдсан төсөв	Зардлын гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	ЗДТГазар	921.1	860.1	61.0	93.4
2	ИТХ	156.9	152.8	4.1	97.4
3	ОНХС	1,384.9	1,289.8	95.1	93.1
4	СХС	172.0	131.1	40.9	76.2
5	НСС	59.2	19.9	39.3	33.6
6	ЭМТөв	32.8	29.3	3.5	89.3
7	Сургууль	179.9	161.8	18.1	89.9
8	Цэцэрлэг	48.6	40.1	8.5	82.5
9	Соёл	142.4	82.9	59.5	58.2
	Дүн	3,097.8	2,767.8	330.0	89.3

М

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 973.5 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 182.2 сая төгрөгийн, нийт 1,155.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс: хангамж, бараа материалын зардалд 2.9 сая төгрөгийг, дотоод албан томилолтын зардалд 2.4 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 937.0 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 78.6 сая төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 16.1 сая төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 9.3 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 13.5 сая төгрөгийг, нийт 1,060.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 95.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн үр ашигтай захиран зарцуулах,

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Ариунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/156 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 3,725.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 37.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. Харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

ИТХ: - Шилэн дансанд байршуулах мэдээ мэдээлэл байршуулаагүйд зөвлөмж хүргүүлсэн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгсөн ба хэрэгжилтийг ирүүлсэн байна.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг даргын тамгын газар	4	519.7	3	162.0	1	357.7	4	519.7	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	47.5	2	46.0	2	1.5	4	47.5	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	3	0.8	1	0.1	2	0.7	3	0.8	-	-	-	-
Дүн	11	568.0	5	208.1	5	359.9	11	568.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	4	1.3	2	0.9	-	-	2	0.3	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	-			1	-	1	-	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	2	75.0					2	75.0				
Дүн	8	76.3	2	0.9	1	-	5	75.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-